

ХУЛГАЙН ГЭМТ ХЭРЭГТ ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА, ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРЭГТ ШИЙТГҮҮЛСЭН ХОРИГДЛЫН СЭТГЭЛ ЗҮЙ

Б.НЯМЛХАГВА

Дотоод хэргийн их сургуулийн

Гэмт явдал судлал-эрх зүйн 7051 дүгээр дамжааны
магистрант

Товч агуулга: Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг түүн дотроос хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, хулгайлах гэмт хэргийг бууруулахад тулгамдсан асуудал бол энэ гэмт хэргийг үйлдэж буй хүний сэтгэл зүй, хандлага, сөрөг зуршилыг өөрчилж хувь хүний авъяас, хөдөлмөрлөх чадварыг хөгжүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагааг зохион явуулах нь үр дүнтэй гэж би үздэг.

Шүүхээс хулгайлах гэмт хэрэгт шийтгэгдэж 405 дугаар ангид ял эдлэж буй хоригдлуудтай ирснээс нь суллагдан гарах хүртэл хугацаанд уулзалт, ярилцлага хийх явцад төрөлхийн хулгай хийх зуршилтай хүн гэж байдаггүй харин хязгааргүй хэрэгцээг хялбархан хангах гэсэн ахархан бодолд автсан, цаашлаад хулгай хийж болох юм байна гэсэн муу зуршилдаа донтсон, сэтгэл зүйн хувьд эмгэг зан үйлтэй бие хүнийг олж хардаг нь харамсалтай.

Сэтгэл зүйн шинжлэх ухаанд буруу үйлээр сэтгэл ханамж буюу ахуйн хэрэгцээг хангах нь сэтгэцийн хувьд эмгэг буюу өвчлөл гэж үздэг. Учир нь хулгайлах гэмт хэрэгт хэт донтсон байдал нь бие хүний тархины нейрохимийн бүтэцэд нөлөөлж допамин хэмээх бодисыг ялгаруулдаг. Энэ бодисын үүрэг нь хүний сэтгэл хөдлөлд нөлөөлж түр хугацаанд сэтгэл санаанд тааламжтай мэдрэмж төрүүлдэг.

Дээрх байдалтай тогтмол хугацаанд явснаараа допамин бодисийн хэмжээ ихсэж хулгай хийхгүй л бол тэвчиж байж чадахгүй болох эмгэг дур буюу дон үүсгэдэг гэж сэтгэл судлаач нар үздэг.

Иймд хулгайлах донтой бие хүнийг учруулсан хохиролд нь тохирох эрүүгийн хуульд заасан ял шийтгэлийг оногдуулж болох боловч сэтгэл зүйн

эмгэг дур буюу донг эмчлэх нь давтан гэмт хэрэгтэн бие хүн төрөхөөс урьдчилан сэргийлэх сайн үр дүнтэй гэж боддог.

Түлхүүр үгс: Өмчлөх эрх, эрүүгийн хариуцлага, сэтгэл зүйн засал, нийгэмшүүлэх.

Key word: Ownership rights, criminal liability, psychological therapy, socialization.

Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэмт хэргийн дийлэнх хувийг бусдын гэмт хэргийг хулгайлах гэмт хэрэг эзэлж байгаа нь хулгайлах гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, өнөөгийн байдлыг бодитой тодорхойлж энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд шинжлэх ухааны шинэлэг санааг амьдралд хэрэгжүүлэх, шинэ боловсон хүчнийг чадавхжуулах, мэдээллийг тэнцвэртэйгээр хүргэх зэрэг зайлшгүй тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зорилгоор энэхүү сэдвийг сонгон авсан болно.

Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг нь 2017 оны байдлаар Монгол улсын хэмжээнд 18176 бүртгэгдснээс 12222 буюу 2/3 хувь нь зөвхөн хулгайлах гэмт хэрэг байгаа нь тулгамдаж буй асуудал болоод байна¹.

“Хулгайлах” гэдэг нь Цэвэлийн Монгол хэлний тайлбар тольд “Амины болон улс, нийгмийн өмч хөрөнгө, эд юмыг сэмээр нууж авах, хулуух, хулгай хийх” гэж тайлбарлагддаг.

Бусдын эд хөрөнгийг хулгайлах гэдэгт бусдын эд хөрөнгийг нуун, далд аргаар, шунахай сэдэлтээр, хүч хэрэглэхгүйгээр, хууль бусаар авч, бүр мөсөн үнэ төлбөргүй өөрийн өмчийн адил захиран зарцуулах боломж бүрдүүлсэн буюу захиран зарцуулсан шууд санаатай үйлдлийг ойлгоно.

Монгол улс нь буурал түүхийнхээ хугацаанд өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэж байсан уламжлалтай бөгөөд Их Монгол Улсын “Их засаг” хуульд хулгай хийсэн хүнийг хүнд хөнгөний байдлаар нь ялгавартай авч үзэж шийтгэж байсан түүхтэй. Мөн энэ хуулийн 49 дүгээр зүйлд “Хулгай хийсэн хүнийг алах, түүний гэргий, мал хөрөнгийг хураан авч хулгайд эд юмсаа алдсан хүнд өгнө” гэж заасан нь тухайн цаг үеийн нийгмийн харилцааг зохицуулах хамгийн зөв шийдэл байснаас гадна хулгайлах гэмт хэрэг үйлдсэн эдгээдийн сэтгэл зүйг өөрчлөхөд чиглэгдсэн нөлөөлөлийн нэг хэлбэрийг харуулсан түүхэн уламжлал байв.

¹ Статисткийн нэгдсэн сангаас ашиглав.

Өнөөгийн байдлаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь шүүхийн шийдвэрийг биелүүлж гэм буруутай этгээдийг нийгэм олон нийтээс шүүхээс оногдуулсан хугацаагаар тусгаарлаж, эрх, эрх чөлөөнд нь хуульд заасан хязгаарлалт тогтоож, хорих ялыг албадан эдлүүлэх явцад бүхий л хугацааг хамарсан нийгмийн харилцаанд ухамсартайгаар бие даан оролцоход дэмжлэг үзүүлэх, чадвахжуулах, хөгжүүлэх, хууль дээдлэх төлөвшлийг бий болгоход чиглэгдсэн² нийгэмшүүлэх үйлчилгээг үзүүлж байгаа боловч анх удаа хорих ялаар шийтгэгдсэн хоригдол нь хулгайн гэмт хэрэгт давтан шийтгэгдсэн хоригдлын зөвлөгөө, юунд алдаа гаргаад, яагаад, баригдах болсон гэх мэт зүйлд архаг гэмт хэрэгтнүүдийн буруу ухуулга нөлөөлөлд автах, тэднээс суралцах магадлал өндөр болохоос гадна хулгайн гэмт хэрэгтнүүд зохион байгуулалтад орох хандлага ихэсч байгааг бодох нь зүйн хэрэг юм.


Улаанбаатар хотын нэгэн дүүргийн судалгаанаас харахад 2017 онд 2306 хулгайлах төрлийн гомдол мэдээлэл бүртгэгдсэн байна. Урд оны мөн үетэй харьцуулахад 22 нэгжээр буюу 1 хувиар өссөн. Мөн 775 буюу 28,8 хувь нь хулгайлах гэмт хэрэг бүртгэгдсэн байна. Урд оны мөн үеэс 346 хэргээр буюу 80,7 хувиар өссөн байна. Хулгайлах гэмт хэргийн 749 буюу 96,6 хувийг хувийн өмчийн хулгай, 19 буюу 2,4 хувийг халаасны хулгайн гэмт хэрэг 15 буюу 1,9 хувийг мал хулгайлах, 8 буюу 1,0 хувийг авто тээврийн хэрэгсэл хулгайлах гэмт хэрэг байна. Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй 768 гэмт хэрэг бүртгэгдсэний 121 хэргийн яллагдагчаар татвал зохих этгээдийг олж тогтоосон ба гэмт хэргийн илрүүлэлт 15,8 хувьтай, урд оны мөн үетэй харьцуулахад илрүүлэлт -22,4 хувиар буурсан байна³.

Хуулийн үгдэслэл: Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйл. Хулгайлах


1.Бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар, хууль бусаар авсан бол хоёр зуун дөчин цагаас долоог зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас таван жил хүртлэх хугацаагаар хорих ял шийтгэнэ гэж заасан байдаг.

² Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль /2017.05.09 шинэчилсэн найруулга/ 218 дугаар зүйл

³ Улаанбаатар хот БЗД-ийн Цагдаагийн 2-р хэлтэс үйл ажиллагааны тайлан



Хулгайлах гэмт хэрэг үйлдэгдсэн цаг



Үйлдэгдсэн газраар нь авч үзвэл гудамж, олон нийтийн газарт, гэр хороололд, гаригаар нь авч үзвэл даваа, мягмар, баасан гаригуудад гэмт хэрэг ихээр үйлдэгдсэн бол цагаар нь авч үзвэл 22-06 цагт нийт хэргийн 23,6 хувь, 19-22 цагт 31,7 хувь, 14-19 цагт 30,2 хувь нь тус тус үйлдэгдэж байгаа нь өндөр үзүүлэлт болж байна⁴.

Энэ судалгаагаар юуг хэлэх гээд байна вэ гэвэл хулгайлах донтой этгээдүүд нь тодорхой өдрийн хувьд тэр дотороо тодорхой цагт хувьд тархины нейрохимийн бүтэцэд нөлөөлж буй допамин хэмээх бодисын ялгаруулалт нэмэгдсэнтэй холбоотой байж болзошгүй юм.

Энэ нь хэвлэл мэдээлэл, телевиз, интернет орчинд гэмт хэрэг үйлдэх сэдэл төрүүлж байна. Жишээ нь эртний эдлэл, бурхан өндөр үнээр авна гэх мэт зараас борлуулах эх үүсвэр байна гэдэг ойлголтыг хулгайч нар төрүүлж, сэдэлжүүлж байна.

Хулгайлах гэмт хэрэг гарч байгаа шалтгааныг ард иргэдийн нэг хэсэг нь хулгайлах гэмт хэрэг гарч байгаа шалтгаан нь ажилгүйдэл, ядуурал

⁴ Улаанбаатар хот БЗД-ийн Цагдаагийн 2-р хэлтэс үйл ажиллагааны тайлан

гэдэгтэй хэн бүхэн санал нийлдэг байсан бол одоо арай өөр өнцгөөс харах шаардлага бий боллоо. Гэхдээ ажилгүйдэл ядуурлыг үгүйсгэх аргагүй.

Учир нь эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нар насанд хүрээгүй хүүхдийг хараа хяналтгүй орхих, эцэг эх нь архичин эсхүл хойд эцэг эхийн хэругийллээс хүүхэд хайрын дутуу дулимагийн мэдрэмжийг авч өсдөг ба өөрийн дутуу дулимагийн мэдрэмжийг бусдын материаллаг хэрэгцээгээр хангах, бусдын бүтээсэн баялагт атаархаж хязгааргүй хэрэгцээг хангах гэсэн сэтгэцийн эмгэгтэй хүмүүсийг олшруулах шалтгаан болсон байна.

Бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэгт шийтгэгдэж хорих ял эдлэж буй хоригдлуудтай уулзалт, ярилцлага хийх явцад хоригдлуудын зүгээс гаргадаг нийтлэг шалтгаан бол хүүхэд байхаасаа гэр бүлийн халуун дулаан харилцааг сайн мэдэхгүй, хүн болсон юм хойно өөрийн хязгааргүй хэрэгцээг хангах шаардлага гардаг учир хялбар аргаар бусдын бүтээсэн баялагыг өөрийн болгох цаашлаад энэ байдалтай байгаагаа ердийн үзэгдэл мэт ойлгож байгаа нь тулгамдсан асуудал болоод байна.

Хорих ангид ч гэсэн сэтгэл зүйн, сэтгэл заслын эмчилгээг хийж болохгүй гэж асуулт урган гарч магадгүй. Учир нь хорих ялаар шийтгэгдсэн этгээд нийгмээс тусгаарлагдсан байдалтай удаан үргэлжлэх тохиолдолд сэтгэл зүйн хувьд өөр эмгэг шинээр бий болох ижил төрлийн гэмт хэрэг үйлдсэн хоригдлуудын нөлөөнд орох хулгайлах арга хэлбэрээ нарийвчлан сайжруулах, гэмт бүлэглэлд элсэх, зохион байгуулалтад шилжих зэрэг сөрөг үр дүн гарч болзошгүй.

Өндөр хөгжилтэй улсуудын жишиг, цаашдын чиг хандлагыг харахад хүчирхийлэл үйлдэгч, архи, мансууруулах бодисонд донтогсод, давтан хулгайлах үйлдэл хийсэн гэмт этгээдүүдийг өвчлөл гэж үзэх хандлагатай байгаа тул тохирох эмчилгээ хийх арга замыг сонгож байгаа нь улс иргэнээ эрүүлжүүлэх бодлого юм.

Сэтгэл заслын эмчилгээ нь сэигэл зүйн онол ба аргууд дээо үндэслэгддэг агаад үйлчлүүлэгчид сэтгэлийн түгшүүр төрүүлдэг мэдрэмж, зан үйлийн эмгэг, сэтгэгдэл, харилцаа, сэтгэл зүйн шинж тэмдгүүдийг арилгах явдлыг зохицуулахаар хувь хүн ба бүлэгт тусламж үзүүлэх системтэй, чиглэл зорилго бүхий үйл ажиллагаа юм.⁵ Энэ нь сэтгэл

засалчын заавар, зөвлөгөө, удирдлагын дагуу сэтгэц-зан үйлийн эмгэгийг өөрчлөхөд чиглэдэг”⁵

Иймд дээрх өвчлөлтэй этгээдүүдийг эмчлэхийн тулд эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, хулгайлах гэмт хэрэгт тохирох сэтгэл зүйн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлснээр хулгайлах гэмт хэрэг буурсан тайван, амгалан Монголд амьдран гэдэгт би итгэдэг.

Хулгайлах гэмт хэрэг үйлдэгч нарт дээр дурьдсанчлан хорихоос өөр төрлийн ял, хөдөлмөр эрхлэх дуршил нэмэгдүүлэх, сэтгэл заслын эмчилгээг нэмэгдүүлснээрээ өмчийн эсрэг гэмт хэрэг буурах, бусдын эд хөрөнгийг хулгайлах давтан гэмт хэрэгтэн засрах, шудрагаар амьдарч сурах хэвшил тогтох эерэг хандлага илрэхээс гадна эдийн засгийн хувьд асар их хэмнэлт гарах нь тодорхой юм.

Учир нь хорих ял эдлэж байгаа нэг хоригдолд өвлийн хувцас 54700 төгрөг, ноосон цамц 15100 төгрөг, өдөр тутам хувцас 25682 төгрөг, дотуур хувцас 6000 төгрөг, малгай 2940 төгрөг, ажлын хувцас 30489 төгрөг, сар бүрийн саван 490 төгрөг, бээлий 400 төгрөг, ор хөнжилийн даавуу 21483 төгрөг, нүүр гарын алчуур 3550 төгрөг, гутал 50000 төгрөг нийт 210884 төгрөгийн хувцас хэрэгсэл, гурил, будаа, мах, элсэн чихэр, төмс, хүнсний ногоо, ургамлын тос, сонгино, масло, цай гэх мэт хүнсний зүйлсийг зах зээлийн ханшаар нь авч үзэхэд 5145 төгрөгийн зардлыг улсын төсвөөс гаргахаас гадна цахилгаан, дулаан гэх мэт ашиглалтын зардалд зарцуулагддаг гэж тооцож үзэхэд багагүй тоо гарч ирэх нь зүйн хэрэг юм⁶.

Харин хорихоос өөр төрлийн ял үүн дотор албадан хөдөлмөр хийлгэж сэтгэл заслын зохих сургалтад хамруулж, нийгмийн дунд нь нийгэмшүүлэх нь эдийн засгийн хувьд хэмнэлт гарч хулгайлах донтой, сэтгэцийн эмгэгтэй хүмүүсийн тоо буурна гэдэгт миний зүгээс итгэлтэй байна.

ДҮГНЭЛТ

Иймд хулгайлах гэмт хэрэг үйлдэж буй иргэдэд хорихоос өөр төрлийн ялаар түлхүү шийтгэх, мэргэжлийн сэтгэл зүйн багаар тэдний эмгэг, донтолтыг тодорхойлуулж сэтгэл заслын эмчилгээнд хамруулах нь нь илүү үр дүнгээ өгөх боломжтой юм.

⁵ О.Мягмар Сэтгэл зүйн зөвлөгөө

⁶ ХЗДХ сайдын 2017 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн А/214-р тушаалын хавсралт Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хоригдлын хоногийн хоол хүнсний хоногт авбал зохих илчлэг норм.

ДЭВШҮҮЛСЭН САНАЛ

1. Цэцэрлэг, ехөнхий боловсролын сургуулийн сурагчдад сэтгэл ханамж, дутуу дулимагийн мэдрэмжийг сэтгэл зүйн шинжлэх ухааны үүднээс ойлгуулж зөв дадалд сургах
2. Мэргэжлийн сэтгэл зүйч нарын багаар тэдний эмгэг, донтолтыг тодорхойлуулж сэтгэл заслын эмчилгээнд хамруулах
3. Хулгайн гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хөдөлмөрийн дадал олгох сургалтад хамруулах

Ном зүй

1. Статистикийн нэгдсэн сангаас ашиглав
2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль/ 2017.05.09 шинэчилсэн найруулга/ 218 дугаар зүйл
3. Улаанбаатар хот БЗД-ийн цагдаагийн 2-р хэлтэс үйл ажиллагааны тайлан
4. О.Мягмар Сэтгэл зүйн зөвлөгөө
5. ХЗДХ сайдын 2017 оны 8 дугаар сарын 31-ний А/214-р тушаалын хавсралт